БАТЛАВ:

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР БӨГӨӨД
ХОТ БАЙГУУЛАЛТ ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА
.................. /Ц.ТУЛГА/

# СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 11 ДҮГЭЭР ХОРОО УС ЗАЙЛУУЛАХ СУВГИЙН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

2021 оны 06-р сарын 03-ны өдөр Дугаар:МЗХ2021/09-21 Улаанбаатар хот

| | | |
|---|---|---|
| 1. | Зураг төсөл боловсруулах үндэслэл | - Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого<br>- Монгол Улсын Их хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг;<br>- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл ;<br>- /Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;<br>- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 02/09 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”;<br>- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 02/10 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”;<br>- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 63 дугаар тогтоолоор батлагдсан “Баянхошуу” нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө<br>- Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/89 дүгээр захирамжаар байгуулагдсан Мэргэжлийн Зөвлөлийн 2021 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 09 дүгээр хурлын шийдвэр<br>- Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газрын 2021 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн 03/1055 тоот албан бичиг |
| 2. | Зураг төсөл боловсруулах үе шат хугацаа | 1 үе шаттай.<br>- I үе шат: Ус зайлуулах сувгийн ажлын зураг төсөв боловсруулах<br>Хугацаа<br>- Гэрээнд заасан хугацаанд |

| | | |
|---|---|---|
| 3. | Байршил, газар эдэлбэрийн одоогийн байдал | - Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 11 дүгээр хороо<br>/Хавсралт-1 схем зураг/ |
| 4. | Ажлын зураг төсөл боловсруулахад ашиглах материал<br><br>НИЙСЛЭЛИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР<br>ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБ<br>2021 оны 06-р сарын 03 өдөр<br>ТТА4518 ... 211/401 | **Монгол Улсын хуулиуд:**<br>- Хот байгуулалтын тухай хууль;<br>- Барилгын тухай Монгол Улсын хууль;<br>- Байгаль орчныг хамгаалах тухай хууль;<br>- Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль;<br>- Усны тухай хууль;<br>- Бусад холбогдох хууль тогтоомжууд<br>**Норм, нормативууд:**<br>- Монгол орны нутаг дэвсгэрт тархсан олон жилийн цэвдэг хөрсөнд инженер-геологийн судалгаа хийх заавар /БД 50-102-08/<br>- Усны барилга байгууламжийн инженер, хайгуул судалгааны ажлын жишиг норм /БД 81-105-11/<br>- Усны барилга байгууламжийн зураг төслийн ажлын жишиг норм /БД 81-106-11/<br>- Усны барилга байгууламжийн зураг төсөл зохиох үндсэн журам /БНбД 33-01-03/<br>- Усны барилга байгууламжийн ачаалал ба үйлчлэл /БНбД 33-05-09<br>- Усны барилга байгууламжийн бетон ба төмөр бетон бүтээц /БНбД 33-06-09<br>- Усны барилга байгууламжийн хайгуул судалгааны ажлын жишиг норм /БД 81-33-10/<br>- Усны барилга байгууламжийн бууръ /БНбД 33-04-09/<br>- Усны барилга байгууламжийн төсвийн суурь норм /БНбД 81-33-10/<br>- Голын гидротехникийн барилга байгууламж /БНбД 33-03-05/<br>- Хот тосгон нутаг дэвсгэр, зам талбайгаас бороо, цасны усыг зайлуулах ажлын зураг төсөл, тооцооны норм /БД40-302-13<br>- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилт /БНбД 30-01-04/<br><br>**Холбогдох журмууд:**<br>- Монгол улсын Засгийн газрын 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 108 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах магадлал хийх дүрэм”<br>- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2018 оны 01 дүгээрс арын 24-ний өдрийн 09 дүгээр тогтоолоор баталсан “Нийслэлийн инженерийн бэлтгэл арга хэмжээний барилга байгууламжийн төлөвлөлт, хамгаалалтын зурвас, ашиглалт засвар үйлчилгээний журам”<br>- Бусад холбогдох журмууд |
| 5. | Ажлын зураг төслийн бүрдэл, шаардлага | - Бэлтгэл ажил (инженер геологийн дүгнэлт, дэвсгэр зургийн тодруулга)<br>- Гидрогеологи, гидрологийн тооцоо судалгаа хийх<br>- Ус зайлуулах сувгийн ажлын иж бүрэн зураг төсөв<br>**Зураг төсөлд тавигдах шаардлага:** |

| | | |
|---|---|---|
| | | - Зураг төслийн баримт бичиг 4 хувь. Үүнээс: график зураглал CD-ний хамт 2 хувийг захиалагчид, үндсэн хувийг архивт өгнө.<br>- Инженерийн шугам сүлжээний ажлын зургийг UTM-координатын системд хийж гүйцэтгэн батлагдсан ажлын зургийг CD-ээр Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын Инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтэст хүлээлгэн өгөх.<br>- Ажлын зурагт бусад инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийг нэг дэвсгэр дээр нэгтгэн, хоорондын зай хэмжээг огтлолын зургаар тодорхой үзүүлж, норм стандартын дагуу төлөвлөж, шугам сүлжээний ашиглалтын байгууллагуудтай зөвшилцсөн байх шаардлагатай. |
| 6. | Инженерийн хангамжийн байгууламжийн үндсэн хийцэд тавигдах шаардлага.<br><br>НИЙСЛЭЛИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР<br>ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБА<br>20 21 оны 06-р сарын 03 өдөр<br>ТПА4518 № 2117401 | **Ус зайлуулах сувгийн байгууламж**<br>- Инженер геологийн судалгаанд үндэслэн цэвдэгтэй болон хөрсний усны түвшинг тооцон хөрсний ус зайлуулах шүүрүүлийн байгууламж төлөвлөх<br>- Болзошгүй үерийн аюулыг 1, 5, 10 %-ийн хангамшлын зарцуулалтыг тодорхойлж, тооцоот зарцуулгыг 1%-ийн хангамшлаар тооцож ус зайлуулах шугам сүлжээ, байгууламж шинээр төлөвлөх<br>- Усны барилга байгууламжийн холболтын цэгийг ашиглагч “ГУББГ,ОНӨААТҮГ”-аас техникийн нөхцөл авч нэгдсэн шугам сүлжээнд холбох<br>- Хаврын шар ус, зуны хур бороoны үед сайр, гуу жалгаар урсан ирэх урсацын хагшаас тогтоон барих байгууламж, үерийн ус хүлээж авах байгууламж, энерги унтраах, тунгаагуурын байгууламж төлөвлөх,<br>- Байгууламжид нийлэх гуу жалга түүний оруулга, дагалдах хийц, бэхэлгээний хийцийн тооцоо хийх, хатуу урсацын хэмжээ тодорхойлох .<br>- Авто замын ус гаргуурыг ус хураах талбай, ус зүйн тооцоо нарийвчлан хийж хөндлөн огтлолын хийцийг төлөвлөх<br>- Трассын дагууд огтлолцож байгаа бусад инженерийн шугам сүлжээг хамгаалах, бэхлэх арга хэмжээг төлөвлөж, эзэмшигч байгууллагуудтай зөвшилцөх, ашиглагч байгууллагаас техникийн нөхцөл гаргуулах, шаардлагатай тохиолдолд шугам сүлжээг шилжүүлэх зургийг боловсруулах.<br>- Трассанд өртөж байгаа нэгж талбаруудыг зурагт тэмдэглэж газар чөлөөлөлтийн зардал тооцох, холбогдох байгууллагуудтай зөвшилцөх, статистик мэдээлэл гаргах, зураг схем гаргаж өгөх.<br>- Байгууламжийн трасст орсон барилга байгууламж, нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн тохижилт, авто замын нөхөн сэргээлтийг төсөвт тусган тооцоо,судалгааг нарийвчлан гаргаж тайлбар бичигт тусгах<br>- Авто замын байгууламжийн доор төлөвлөж буй хэсгийг сувган байгууламжид оруулах |

| | | |
|---|---|---|
| | | - Хэтийн төвөгшлийн зэргийг тооцож зөв оновчтой трасс сонголтыг хийх |
| 7. | Шугам сүлжээний трасс сонголтонд тавигдах шаардлага | - Авто зам, төмөр зам, инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг тогтоох.<br>- Бусад инженерийн шугам сүлжээний төлөвлөсөн ажлын зурагтай уялдуулах<br>- Шаадлагатай тохиолдолд хонгилын систем төлөвлөх |
| 8. | Эдийн засгийн тооцоо, төсөв | - Эдийн засгийн тооцоог УББ 80-204-16 “Хөрөнгө оруулалтын үр ашгийг тооцох заавар”-аар, төсвийг БНбД 81-95-12 болон эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн програмаар тооцно.<br>- Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан төсвийг үе шаттайгаар тооцох<br>- Одоо байгаа авто зам, замын хөндлөн гарах гаргалгааны хэсэгт мэргэжлийн байгууллагаас тавьсан шаардлагыг нарийвчлан тусгаж, нөхөн сэргээлтийн зардлыг төсөвт тусгана. |
| 9. | Зураг төсөл боловсруулах байгууллага | Зөвлөх үйлчилгээний **1.3.5** “Усны барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах”тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж эсвэл **ЗТ-2.2, ЗТ-3.2, ЗТ-4.2, ЗТ-5.2** “Усны барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах”тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж |
| 10. | Зураг төслийн санхүүжилт | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр |
| 11. | Төслийн захиалагч | - Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газар |
| 12. | Галын аюулгүй байдлын нөхцөл | - Барилга, байгууламжийн галын аюулгүйн байдал БНбД 21.01.02<br>- Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм БНбД 21.02.02 |
| 13. | Байгаль орчны үнэлгээ нөхцөл | Шаардлагатай тохиолдолд байгаль орчны үнэлгээ хийлгэх |
| 14. | Онцгой нөхцөл (Төлөвлөлтийн шаардлагаар гарах нэмэлт шаардлагууд трассын дагуух газар чөлөөлөх, хөрсний шинж чанараас хамаарсан нэмэлт төлөвлөлт, шинэ техник технологи хэрэглэх гэх мэт) | - Трассын дагуу хөндлөн гарч байгаа 110 кВт цахилгаан дамжуулах агаарын шугамын хэсгийг Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ,ТӨХК-тай зөвшилцөх<br>- Одоо байгаа болон төлөвлөлтийн талбай орчмын байгалийн жалгаараа байгаа үерийн сувгийн ашиглалтын түвшин тодорхойлж уялдуулан төлөвлөх<br>- Ус зайлуулах байгууламжийн ажлын зургийг даалгаварын тогтоосон байршилд гаргалгааг тооцож холболтын цэгийг тогтоох<br>- Ус зайлуулах сувгийн хамгаалалтын зурвасын дагуу тохижилтын ажил хийх, орчны аюулгүй байдлыг хангах<br>- Ус зайлуулах хоолойн байгууламж, шугам сүлжээний ашиглалт, техникийн засвар үйлчилгээнд зориулан явган хүний зам, авто машины гүүр, явган хүний гүүр |

НИЙСЛЭЛИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР
ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБА
20 21 оны 06-р сарын 03 өдөр
ТТА4518 ☎ 2117401

| | | |
|---|---|---|
| | | зэргийг орчны тохижилт төлөвлөлттэй уялдуулан норм дүрмийг хангаан төлөвлөх.<br>- Ус дахин ашиглах боломжийн судалгаа, ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлт, усалгаа, зам талбайн угаалга, машин угаалгын газарт ашиглахаар тусгах |

ХЯНАСАН:

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ОРЛОГЧ ДАРГА М.ШИЖИРБАЯР

ЗӨВШӨӨРСӨН:

ХОТЫН ИНЖЕНЕРИЙН БАЙГУУЛАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ М. БАЛДАНДОРЖ

"ГЕОДЕЗИ, УСНЫ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ГАЗАР",
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА Л.АРИУНТУЯА

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР, ИНЖЕНЕРИЙН ДЭД
БҮТЦИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Б.ОЮУНТУЯА

БОЛОВСРУУЛСАН:

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР, ИНЖЕНЕРИЙН ДЭД
БҮТЦИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН УСНЫ БАРИЛГА
БАЙГУУЛАМЖ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.ЦОЛМОН

ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБА
2021 оны 06 -р сарын 03 өдөр

# СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 11 ДҮГЭЭР ХОРООНЫ УС ЗАЙЛУУЛАХ СУВГИЙН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ МЗХ2021/09-21 ДУГААРТАЙ ДААЛГАВРЫН ХАВСРАЛТ СХЕМ

*ШИЙДВЭР: НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2021 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 29-НЫ ӨДРИЙН А/41 ЗАХИРАМЖ, НИЙСЛЭЛИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР 2021 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ*

**ЗАХИАЛАГЧ:** СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**БАЙРШИЛ :** СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 11 ДҮГЭЭР ХОРОО




**11 хороо төлөвлөлт:**

Төлөвлөж буй ус зайлуулах суваг L=510 м,
Суваг хийх гудамжинд айлын хаалга болон машин зорчих хэсэгт хүчитгэсэн хавтантай хийхээр төлөвлөх шаардлагатай.

НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2021.05.19 № 03/1055

"ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАРТ"

Даалгавар хүсэх тухай

Тус дүүргийн 8, 11 дүгээр хороодод нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд ус зайлуулах хоолой болон сувгийн ажил хийгдэхээр батлагдсан тул зураг, төсөл боловсруулах даалгавар боловсруулж өгнө үү.

1 дүгээр хавсралт: 8 дугаар хорооны байршлын зураг, 1 хуудастай.
2 дугаар хавсралт: 11 дүгээр хорооны байршлын зураг, 1 хуудастай.
3 дугаар хавсралт: Эрх шилжин ирсэн захирамж, 2 хуудастай.
4 дүгээр хавсралт: Нэмэлт мэдээлэл, 1 хуудастай.

Нийслэлийн сонгинохайрхан дүүргийн засаг даргын тамгын газар
Удирдлага
Тамгын Газрын Дарга
Долгор Төмөрбаатар
2021.05.19 16:51

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 29 өдөр Дугаар А/41 Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар батлаж, уг төсөл, арга хэмжээний эрхийг Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга /Н.Алтаншагай/-д шилжүүлэн, худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, захиалагчийн хяналт тавьж ажиллахыг үүрэг болгосугай.

2.Энэ захирамжийн хавсралтуудад заасан төсөл, арга хэмжээг холбогдох хууль, журамд нийцсэнийг үндэслэн санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Н.Наранбаатар/-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар /М.Баяраа/-т тус тус даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ Д.СУМЪЯАБАЗАР

НИЙСЛЭЛИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР
ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБА
2021 оны 06-р сарын 03 өдөр
1110200000285
ТТА4518 ... 2117401